**СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн  2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2024/03/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Хөвсгөл аймаг<br>2024 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын<br>Дарга,тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114  Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn<br><br>Аудитор: Ахлах аудитор: Б.Даваанямь<br>Утас: 88095436  Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn<br><br>Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн<br>Захирал: Ч.Энхчимэг<br>Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn<br><br>Аудитор: Д.Мядагмаа<br>Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/233

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА
Г.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Эрүүл мэндийн яамнаас 899,634.3 мянган төгрөгийн Nissan Patrol Y61 автомашин, ходоодны дуран, эмнэлгийн хог хаягдлын устгах автоклав, WATO EX-55 маркийн унтуулгын аппарат зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн зарцуулалттай холбоотой 3,018.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. 2022 онд худалдан авсан 2 орон сууцны үл хөдлөх хөрөнгийн эзэмшигчийн гэрчилгээ нь байгууллагын нэр дээр шилжээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын дарга нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлөөр 4 зорилт 93 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж 96.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

6724040559

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,247,738,777.33** | **2,628,504,252.06** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 122,107,244.00 | 11,647,106.51 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 122,107,244.00 | 11,647,106.51 |
| **3121** | **Төгрөг** | 122,107,244.00 | 11,647,106.51 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 122,107,244.00 | 11,647,106.51 |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 586,818,252.41 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 586,204,820.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 613,432.41 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 613,432.41 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 2,125,631,533.33 | 2,030,038,893.14 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,644,834,917.41 | 1,439,249,356.56 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 199,367,670.46 | 221,568,582.02 |
| 35130 | Эм боох материал | 1,445,467,246.95 | 1,217,680,774.54 |
| **354** | **Хангамжийн материал** | 480,796,615.92 | 590,789,536.58 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 554,735.00 | 796,660.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 82,942,627.83 | 117,424,929.13 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 419,500.00 | 9,788,400.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 497,124.60 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,861,500.00 | 3,443,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 13,920,380.50 | 12,768,646.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 381,097,872.59 | 446,070,276.35 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **17,517,409,734.96** | **16,331,970,639.54** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 17,517,409,734.96 | 16,331,970,639.54 |
| **392** | **Биет хөрөнгө** | 16,396,303,485.00 | 15,204,744,389.62 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,491,558,108.13 | 9,516,915,562.13 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,634,714,876.44 | -2,109,683,356.24 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 507,855,380.00 | 703,237,673.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -210,559,427.31 | -298,919,833.63 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 10,941,089,968.35 | 11,438,046,525.41 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -3,198,565,978.89 | -4,526,046,685.97 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 634,323,940.32 | 705,199,629.32 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -224,032,766.78 | -296,905,320.56 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 154,208,413.40 | 154,208,413.40 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -64,859,275.78 | -81,308,217.24 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,121,106,249.96 | 1,127,226,249.92 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,121,782,500.00 | 1,128,432,500.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -676,250.04 | -1,206,250.08 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **19,765,148,512.29** | **18,960,474,891.60** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **1,311,959,941.63** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 1,311,959,941.63 |

| | | | |
|---|---|---|---|
| **413** | **Өглөг** | 00.00 | 1,311,959,941.63 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 1,311,693,956.63 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 265,985.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 265,985.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **19,765,148,512.29** | **17,648,514,949.97** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 19,765,148,512.29 | 17,648,514,949.97 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 7,126,931,228.10 | 7,126,931,228.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 7,126,931,228.10 | 7,126,931,228.10 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 8,219,017,503.47 | 6,102,484,408.15 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 8,219,017,503.47 | 8,219,117,970.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -2,116,633,562.32 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,419,199,780.72 | 4,419,099,313.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **19,765,148,512.29** | **18,960,474,891.60** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **18,518,021,519.82** | **18,100,453,409.66** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,124,729,229.82** | **1,744,260,939.66** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,124,729,229.82 | 1,744,260,939.66 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 466,813,241.00 | 426,425,387.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 452,024,241.00 | 426,425,387.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,789,000.00 | 00.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө | 00.00 | 968,991,753.80 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ | 00.00 | 348,843,898.86 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **13,393,292,290.00** | **16,356,192,470.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 26,224,000.00 | 4,516,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,000,000.00 | 4,516,900.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 224,000.00 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 13,367,068,290.00 | 16,351,675,570.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 13,367,068,290.00 | 16,351,675,570.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **16,804,642,522.81** | **20,217,043,638.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **16,804,642,522.81** | **20,217,043,638.46** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 16,782,840,250.81 | 20,207,940,658.46 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 7,972,199,654.73 | 9,722,138,057.79 |
| 210101 | Үндсэн цалин | 5,475,991,751.92 | 4,709,093,099.92 |
| 210102 | Нэмэгдэл | 1,910,060,354.80 | 3,602,281,437.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 311,859,044.80 | 610,898,399.43 |
| 210104 | Урамшуулал | 274,288,503.21 | 746,945,121.16 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 52,920,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,005,015,671.03 | 1,233,045,667.33 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 701,444,810.84 | 862,569,993.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 78,382,676.56 | 92,415,614.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 61,993,800.93 | 73,558,431.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,732,806.01 | 18,201,146.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 148,461,576.69 | 186,300,481.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,478,043,321.81 | 1,671,582,693.54 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 112,246,866.18 | 145,273,515.93 |
| 210302 | Түлш, халаалт | 818,742,945.48 | 1,000,021,985.46 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 547,053,510.15 | 524,579,392.15 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 1,707,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 236,916,120.70 | 321,920,677.89 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,860,000.00 | 18,669,460.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 80,221,843.50 | 101,465,138.65 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,157,417.72 | 17,563,563.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 16,240,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,308,300.00 | 7,370,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 46,266,953.27 | 62,340,730.93 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 65,861,606.21 | 114,511,785.31 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,816,032,475.71 | 4,514,458,207.94 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,651,278,901.21 | 4,329,644,163.94 |
| 210502 | Хоол, хүнс | 164,753,574.50 | 184,814,044.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 98,729,234.00 | 204,967,494.27 |
| 210604 | Урсгал засвар | 98,729,234.00 | 204,967,494.27 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 36,230,000.00 | 27,516,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 36,230,000.00 | 27,516,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 107,269,813.68 | 139,314,539.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 77,223,518.00 | 115,940,506.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,900,000.00 | 2,660,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,159,400.00 | 96,525.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 472,510.68 | 745,428.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 330,000.00 | 330,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 197,880.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 4,123,425.00 | 6,674,055.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 16,863,080.00 | 12,868,025.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,032,403,959.15 | 2,372,997,320.70 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,236,349.00 | 21,245,085.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,922,167,610.15 | 2,351,752,235.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21,802,272.00 | 9,102,980.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,802,272.00 | 9,102,980.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 21,802,272.00 | 9,102,980.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,713,378,997.01** | **-2,116,590,228.80** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 4,271,811.45 | 43,333.52 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 4,271,811.45 | 43,333.52 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -4,271,811.45 | -43,333.52 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,709,107,185.56** | **-2,116,633,562.32** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **16,122,200,849.00** | **16,198,945,414.81** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **468,096,081.00** | **428,957,764.81** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 468,096,081.00 | 428,957,764.81 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 468,096,081.00 | 428,957,764.81 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 453,307,081.00 | 428,957,764.81 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,789,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **15,654,104,768.00** | **15,769,987,650.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 44,708,068.44 | 4,516,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,000,000.00 | 4,516,900.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 224,000.00 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 15,609,396,699.56 | 15,765,470,750.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 15,609,396,699.56 | 15,765,470,750.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **15,718,796,182.56** | **16,112,040,832.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **15,718,796,182.56** | **16,112,040,832.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **15,696,993,910.56** | **16,102,937,852.30** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 7,960,119,554.73 | 9,699,206,057.79 |
| 210101 | Үндсэн цалин | 4,203,777,709.92 | 4,709,093,099.92 |
| 210102 | Нэмэгдэл | 2,764,298,756.80 | 3,602,281,437.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 440,641,682.80 | 587,966,399.43 |
| 210104 | Урамшуулал | 551,401,405.21 | 746,945,121.16 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 52,920,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,001,578,192.46 | 1,233,045,667.33 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 698,007,332.27 | 862,569,993.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 78,382,676.56 | 92,415,614.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 61,993,800.93 | 73,558,431.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,732,806.01 | 18,201,146.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 148,461,576.69 | 186,300,481.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,580,386,183.01 | 1,050,525,438.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 112,246,866.18 | 145,273,515.93 |
| 210302 | Түлш, халаалт | 921,085,806.68 | 512,051,046.32 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 547,053,510.15 | 391,493,076.15 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 1,707,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 170,981,413.59 | 262,826,621.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,099,350.00 | 18,837,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 79,981,843.50 | 101,038,863.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,157,417.72 | 17,563,563.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,138,030.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,358,300.00 | 7,370,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 59,246,472.37 | 118,016,795.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,490,807,245.09 | 3,474,895,267.28 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,270,908,305.96 | 3,191,711,807.32 |
| 210502 | Хоол, хүнс | 178,110,270.00 | 206,594,310.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 41,788,669.13 | 76,589,149.96 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 168,215,314.00 | 194,555,176.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 45,747,400.00 | 1,506,720.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 19,420,500.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 103,047,414.00 | 193,048,456.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 36,230,000.00 | 27,516,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 36,230,000.00 | 27,516,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 198,211,658.68 | 139,388,524.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 168,223,518.00 | 115,940,506.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,900,000.00 | 2,660,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,159,400.00 | 96,525.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 472,510.68 | 745,428.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 330,000.00 | 330,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 197,880.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 4,123,425.00 | 6,674,055.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 16,804,925.00 | 12,942,010.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 90,464,349.00 | 20,979,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 90,464,349.00 | 20,979,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **21,802,272.00** | **9,102,980.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,802,272.00 | 9,102,980.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 21,802,272.00 | 9,102,980.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **403,404,666.44** | **86,904,582.51** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **298,929,500.00** | **197,364,720.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **298,929,500.00** | **197,364,720.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 298,929,500.00 | 197,364,720.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 298,929,500.00 | 197,364,720.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-298,929,500.00** | **-197,364,720.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 104,475,166.44 | -110,460,137.49 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 17,632,077.56 | 122,107,244.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 122,107,244.00 | 11,647,106.51 |

## 2.4 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **7,126,931,228.10** | **4,419,199,780.72** | **8,219,017,503.47** | 19,765,148,512.29 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 100,467.00 | 100,467.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **7,126,931,228.10** | **4,419,199,780.72** | **8,219,117,970.47** | 19,765,248,979.29 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -100,467.00 | 00.00 | -100,467.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -2,116,633,562.32 | -2,116,633,562.32 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **7,126,931,228.10** | **4,419,099,313.72** | **6,102,484,408.15** | 17,648,514,949.97 |

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 18,306,475,400.00 | 16,309,405,552.30 | 1,997,069,847.70 | 89% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 18,306,475,400.00 | 16,309,405,552.30 | 1,997,069,847.70 | 89% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 18,283,295,400.00 | 16,300,302,572.30 | 1,982,992,827.70 | 89% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 9,789,506,100.00 | 9,699,206,057.79 | 90,300,042.21 | 99% |
| 210101 | Үндсэн цалин | 4,709,093,100.00 | 4,709,093,099.92 | 0.08 | 100% |
| 210102 | Нэмэгдэл | 3,618,184,000.00 | 3,602,281,437.28 | 15,902,562.72 | 100% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 647,669,100.00 | 587,966,399.43 | 59,702,700.57 | 91% |
| 210104 | Урамшуулал | 743,999,900.00 | 746,945,121.16 | (2,945,221.16) | 100% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 70,560,000.00 | 52,920,000.00 | 17,640,000.00 | 75% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,244,001,600.00 | 1,233,045,667.33 | 10,955,932.67 | 99% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 855,336,500.00 | 862,569,993.23 | (7,233,493.23) | 101% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 96,128,300.00 | 92,415,614.64 | 3,712,685.36 | 96% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 76,902,500.00 | 73,558,431.56 | 3,344,068.44 | 96% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 19,225,600.00 | 18,201,146.38 | 1,024,453.62 | 95% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 196,408,700.00 | 186,300,481.52 | 10,108,218.48 | 95% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,758,890,200.00 | 1,050,525,438.40 | 708,364,761.60 | 60% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 168,722,000.00 | 145,273,515.93 | 23,448,484.07 | 86% |
| 210302 | Түлш, халаалт | 1,064,087,600.00 | 512,051,046.32 | 552,036,553.68 | 48% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 522,665,000.00 | 391,493,076.15 | 131,171,923.85 | 75% |
| 210304 | Байрны түрээс | 3,415,600.00 | 1,707,800.00 | 1,707,800.00 | 50% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 300,678,000.00 | 270,934,741.50 | 29,743,258.50 | 90% |
| 210401 | Бичиг хэрэг | 22,786,000.00 | 18,837,400.00 | 3,948,600.00 | 83% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 108,720,000.00 | 101,038,863.50 | 7,681,136.50 | 93% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 18,112,200.00 | 17,563,563.00 | 548,637.00 | 97% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,994,000.00 | 7,370,000.00 | 2,624,000.00 | 74% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 141,065,800.00 | 126,124,915.00 | 14,940,885.00 | 89% |
| **2105** | **Нормативт зардал** | 4,568,846,800.00 | 3,474,895,267.28 | 1,093,951,532.72 | 76% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,178,651,900.00 | 3,191,711,807.32 | 986,940,092.68 | 76% |
| 210502 | Хоол, хүнс | 272,060,400.00 | 206,594,310.00 | 65,466,090.00 | 76% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 118,134,500.00 | 76,589,149.96 | 41,545,350.04 | 65% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 422,097,600.00 | 383,811,776.00 | 38,285,824.00 | 91% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 139,507,000.00 | 133,787,120.00 | 5,719,880.00 | 96% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 66,897,600.00 | 56,976,200.00 | 9,921,400.00 | 85% |
| 210604 | Урсгал засвар | 215,693,000.00 | 193,048,456.00 | 22,644,544.00 | 90% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 31,935,200.00 | 27,516,000.00 | 4,419,200.00 | 86% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 31,935,200.00 | 27,516,000.00 | 4,419,200.00 | 86% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 108,761,000.00 | 139,388,524.00 | (30,627,524.00) | 128% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 108,761,000.00 | 115,940,506.00 | (7,179,506.00) | 107% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,660,000.00 | 2,660,000.00 | - | 100% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,159,400.00 | 96,525.00 | 6,062,875.00 | 2% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 754,800.00 | 745,428.00 | 9,372.00 | 99% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 363,000.00 | 330,000.00 | 33,000.00 | 91% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 569,300.00 | - | 569,300.00 | 0% |
| 210807 | Газрын төлбөр | 6,674,200.00 | 6,674,055.00 | 145.00 | 100% |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 19,440,000.00 | 12,942,010.00 | 6,497,990.00 | 67% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,958,200.00 | 20,979,100.00 | 979,100.00 | 96% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,958,200.00 | 20,979,100.00 | 979,100.00 | 96% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,180,000.00 | 9,102,980.00 | 14,077,020.00 | 39% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,180,000.00 | 9,102,980.00 | 14,077,020.00 | 39% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,180,000.00 | 9,102,980.00 | 14,077,020.00 | 39% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 18,306,475,400.00 | 16,198,945,414.81 | 2,107,529,985.19 | 88% |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 18,306,475,400.00 | 15,765,470,750.00 | 2,541,004,650.00 | 86% |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 16,366,336,100.00 | 15,765,470,750.00 | 600,865,350.00 | 96% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 634,608,300.00 | 428,957,764.81 | 205,650,535.19 | 68% |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 634,608,300.00 | 428,957,764.81 | 205,650,535.19 | 68% |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,183,423,800.00 | 4,516,900.00 | 1,178,906,900.00 | 0% |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 122,107,200.00 | - | 122,107,200.00 | 0% |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 122,107,244.00 | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 11,647,106.51 | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 435 | 413. | 22. | 95% |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 385 | 363 | 22 | 94% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 49 | 49 | - | 100% |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **413** | **413** | - | 100% |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 351 | 351 | - | 100% |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 62. | 62 | - | 100% |

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28,075.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 25,057.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,018.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулагдаагүй зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 3,018.1 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 266,874.3 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

*Илрүүлэлт*: Томилолтын зардалтай хоолны мөнгийг 86 хүнд 2,405.0 мянган төгрөг давхардуулсан, Мөн 2 хүнд 24.0 мянган төгрөгний томилолт илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;/* заалт болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

### 3.2 Албан шаардлага

*Илрүүлэлт*: Хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг Нийгмийн даатгалын тайланд 01 кодоор тайлагнасан. Ажилтнаас 294.5 мянган төгрөгийг илүү суутган авч нийгмийн даатгалын санд 589.1 мянган төгрөгийг илүү төлсөн байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1."*Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө"* гэсэн заалт болон тайлант хугацааны нийгмийн даатгалтай холбоотой зардал нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

### 3.3 Зөвлөмж

1. **Үндсэн хөрөнгийн гэрчилгээтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* 2022 онд худалдан авсан 2 орон сууцны үл хөдлөхийн эзэмшигчийн гэрчилгээ нь байгууллагын нэр дээр шилжээгүй байгаа нь өмчлөх эрх үүсээгүй эрсдэлтэй байна. Энэ нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5.1."*Иргэн, хуулийн этгээд улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.1-д заасан эрхийг хуульд заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх үүснэ"* гэсэн заалт болон тайлант хугацааны эцэс дэх холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын шалгуурт нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан 2 орон сууцны үл хөдлөхийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлэн авах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 25-ний

өдрийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын орлого, зарлагыг илүү тайлагнасан. | 1 | 25,057.8 | | | 1 | 25,057.8 | 1 | 25,057.8 | | |
| **Дүн** | **1** | **25,057.8** | | | **1** | **25,057.8** | **1** | **25,057.8** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Томилолтын зардалтай хоолны мөнгийг 86 хүнд 2405.0 мянган төгрөг давхардуулсан, 2 хүнд томилолтын зардал 24.0 мянган төгрөг илүү олгосон нийт 2429.0 мянган төгрөг илүү олгосон байна | 1 | 2,429.0 | 1 | 2,429.0 | | | | |
| Хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг нийгмийн даатгалын тайланд үндсэн ажилтнаар тайлагнаж нийгмийн даатгалын шимтгэл илүү төлсөн. | 1 | 589.1 | | | 1 | 589.1 | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | 3 | **3018.1** | **1** | **2,429.0** | 1 | **589**.1 | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**
/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 2022 онд худалдан авсан 2 орон сууцны үл хөдлөхийн эзэмшигчийн гэрчилгээ нь байгууллагын нэр дээр шилжээгүй байгаа нь өмчлөх эрх үүсээгүй эрсдэлтэй байна. | 1 | | | | | | 1 | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр № 57/А2270439/ХӨА-2024/03 НА-СТА-ТШЗ Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 2,429,000.0 /хоёр сая дөрвөн зуун хорин есөн мянга/ төгрөгийг хоолны мөнгийг томилолтын хоолны зардалтай давхардуулж олгосон, 2 хүнд илүү томилолтын зардал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 2,429,000.0 /хоёр сая дөрвөн зуун хорин есөн мянга/ төгрөгийн хоол, томилолтын мөнгийг Хөвсгөл аймгийн Төрийн сангийн 10170000955 /Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Г.Оюунжаргал, нягтлан бодогч Д.Алтантуяа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.ЭНХЧИМЭГ

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724020206

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 09 сарын 26 өдөр № 34/А2970439/ХӨА-2024/03/НА-СТА-ТШЗ Мөрөн сум

*Зөрчил арилгах тухай*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын тайланд Хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг 01 кодоор тайлагнаж нийгмийн даатгалын шимтгэл 589,085.13 /таван зуун наян есөн мянга наян таван төгрөг арван гурван мөнгө/ төгрөг илүү төлсөн.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-т " Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ: орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.",* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрүүтэй тайлагнасан Нийгмийн даатгалын тайланг нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, зөрчлийг арилган, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Г.Оюунжаргал, нягтлан бодогч Д.Алтантуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.ЭНХЧИМЭГ

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724020134